



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**


2020/06



АГУУЛГА



Бүртгэлтэй ажилгүйчүүд



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны хагас жилийн байдал)

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 6 дугаар сарын эцэст 1040 байгаа нь өмнөх оны мөн үеэс 525 (101.9%) хүнээр, өмнөх сараас 46 (4.6%) хүнээр өсч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 498 (47.9%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 22 (2.1%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 12 (54.5%) эмэгтэйчүүд байна.

2020 оны 6 дугаар сард ажилгүй 161 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 24 иргэн ажилд зуулчлагдан орж, 115 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг сургууль төгссөн иргэд 20.5 хувь нь, хамгийн бага хувийг цэргээс халагдсан иргэд буюу 2.5 хувь нь эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 56.4 хувийг бүрэн дунд, 22.7 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.9 хувийг техник мэргэжлийн, 6.1 хувийг суурь, 3.9 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.4 хувийг бага, 1.6 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 51.8 хувийг 15-34 насны залуучууд, 42.1 хувийг 35-54 насныхан, 6.1 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.

Хөдөлмөр, Халамжийн газарт
бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 6
сарын байдлаар




Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2020 оны 6
сарын эцэст




ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 6 сарын байдлаар 711 эх амаржиж, 715 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 45 (6.7%)-аар, амьд төрсөн хүүхэд 41 (6.1%)-аар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2020 оны эхний 6 сард 8 болж, өмнөх оны мөн үеэс 7 (46.7%)-аар буурсан байна.




Халдварт өвчнөөр өвчлөгчид 159 болж, өмнөх оны мөн үеэс 63 (28.0%)-аар буурахад гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 9 (93.8%)-аар, салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 76 (93.4%)-аар, заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 11 (3.9%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин трихоминиаз өвчнөөр өвчлөгчид 2 (33.3%), тэмбүү 17 (36.9%) сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 4 (26.7%) өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2020 оны 6 сарын байдлаар



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2020 оны 6 дугаар сард 25.1 мянган иргэнд 4 тэрбум 420.3 сая төгрөг олгожээ. Үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 2 тэрбум 783.8, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 19.6, алдарт эхийн одонгийн тусламжид 648.3, хүнс тэжээлд 281.4, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид 29.5, насны хишиг 395.4, цалинтай ээж 131.8 сая, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж 97.5 сая, ОНОТХҮйлчилгээ 33.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын шимтгэлээр 9 тэрбум 273.0 сая төгрөг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн санхүүжилтээр 12 тэрбум 902.9 сая төгрөг, бүгд 22 тэрбум 175.9 сая төгрөгийн эх үүсврийн орлого төвлөрүүлж, тэтгэврийн даатгалын сангаас 8305 иргэнд 17 тэрбум 661.1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 793 даатгуулагчид 748.3 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 23 даатгуулагчидад 48.8 сая, ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлсэн 68 иргэнд 142.3 сая төгрөгийн зардлыг тус тус бүрэн олгожээ.

ТӨСВИЙН ОРЛОГО

Аймгийн нийт орлого 30.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөөг 102.0 хувиар давуулан биелүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 4.3 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 112.8 хувиар, үүнээс татварын орлого 3.7 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 124.9 хувиар тус тус давуулан биелүүлсэн бол татварын бус орлого 543.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 66.1 хувийг биелэлтэй байна.

Орон нутгийн төсвийн байгууллагууд 19.1 сая төгрөгийн авлагатай, 182.3 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумууд 104.0-258.9 хувиар давуулан биелүүлсэн байна.


ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ 2020 оны IV сард



Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 77.2 хувийг санхүүжүүлэв. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 90.3%, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 93.5%, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 88.9%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 86.6%, хангамж, бараа материалын зардлын 65.7%, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 53.4%, эд хогшил, эд хогшил, урсгал засварын зардлын 66.5%, томилолт, зочны зардлын 95.7%, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын 89.7%, бараа үйлчилгээний бусад зардлын 76.9%, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны 72.3%, урсгал шилжүүлэгийн 72.2 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА ХУВИАР




- Бараа үйлчилгээний бусад зардал
- Цалин хэлс болон нэмэгдэл урамшил
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал
- Хангамж, бараа материалын зардал
- Нормативт зардал
- Эд хогшил, урсгал засварын зардал
- Томилолт, зочны зардал
- Бусад
- УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ


АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 6 дугаар сарын байдлаар 6 тэрбум 606.6 сая төгрөгт хүрчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 81.1 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 6.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 12.5 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 6 тэрбум 967.8 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, 6 сар, сая төгрөг



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 6 сар, хувиар



- Уул уурхай, олборлох аж үйлдвэр
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 06 сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувь, жилийн эцсээс 3.0 хувиар өссөн, өмнөх сараас 0.9 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020-06 2019-06	2020-06 2019-12	2020-06 2020-05
Ерөнхий индекс	100.0	103.4	103.0	100.9
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	103.9	113.8	103.6
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.1	101.4	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.6	101.6	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.0	100.3	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	103.0	101.1	100.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	106.9	104.1	100.0
Тээвэр	12.2	94.5	95.5	99.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.6	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.5	100.5	100.5
Боловсролын үйлчилгээ	4.7	112.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.6	100.4	100.4
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.2	100.3	100.0

Ерөнхий индекс 2020 оны 05 сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 3.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Банк

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 06 сард 118.4 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харицахын үлдэгдэл 2020 оны 06 сард 26.6 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 20.7 тэрбум буюу 77.9 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 06 сард 110.4 тэрбум төгрөгт хүрчээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

(Сая төгрөг, тоогоор)

Үзүүлэлт		Үлдэгдэл
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	118,419.9
	Үүнээс: <i>Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл</i>	807.3
	<i>Чанаргүй зээлийн үлдэгдэл</i>	1,077.6
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	26,596.7
	Үүнээс: <i>Иргэдийн харилцахын үлдэгдэл</i>	20,711.4
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	110,355.4
	Үүнээс: <i>Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл</i>	108,875.4
	<i>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</i>	32,999.2
	<i>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</i>	77,356.2
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	45
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	190
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	21428
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	111248
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	52853
	Нийт АТМ-ны тоо	22
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	46766

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 2020 оны 6 дугаар сарын байдлаар төллөх насны 1524.9 мянган хээлтэгч малын 1241.9 мянга буюу 81.4 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 80.6 хувь, эм хонины 85.9 хувь, гүүний 72.3 хувь, үнээний 72.6 хувь, ингэний 72.3 хувь нь төллөжээ. Нийт гарсан төл 1231.4 мянган болж 99.0 хувьтай бойжиж байна.

Том малын зүй бусын хорогдол 2020 оны 6 дугаар сард аймгийн хэмжээнд 10118 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 27114 толгой буюу 3.7 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 595, үхэр 476, тэмээ 38, хонь 2891, ямаа 6118 байна. Нийт хорогдлын 28.5 хувийг хонь, 60.5 хувийг ямаа эзэлж байна.

Хорогдсон том мал, 2020 оны 6-р сарын байдлаар



Хорогдсон хээлтэгч мал, 2020 оны 6-р сарын байдлаар



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2020 оны 6 дугаар сард аймгийн төв буюу Есөнбулаг суманд ноолуур 50.0 мянган төгрөг, тэмээний шир 15.0 манган төгрөг, адууны шир 5.0 манган төгрөг, үхрийн шир 2.0-3.0 манган төгрөг, хонины арьс 1000 төгрөг, ямааны ноолуургүй арьс 200 төгрөг байна.

Тариалалт: Аймгийн хэмжээнд үр тариа 410 га, төмс 87.4 га, хүнсний ногоо 67.4 га, тэжээлийн ургамал 723.6 га, нийт 1288.4 га-д тариалалт хийгдээд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үр тариа 82.1 га, тэжээлийн ургамал 99.1 га-гаар тариалалт нэмэгдсэн байна.

Онцгой байдлын газрын мэдээ: Газар хөдлөлт болсон тухай

1. Эрдэнэ сумын Өлзийт багийн “Ямаан ус” гэдэг газар сумын төвөөс баруун зүгт 30 км-т /Ө-45°51'00", У-97°32'00"/ 2020.02.12-ны өдрийн 07:10 цагт 4.7 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон тухай мэдээллийг 2019.02.12-ны өдрийн 08:40 цагт хүлээн авсан.

2. Жаргалан сумын Завхан гол багийн нутагт сумын төвөөс зүүн зүгт 14 км-т /Ө-46°95'00", У-96°10'00"/ 2020.02.17-ны өдрийн 11:14 цагт 4.5 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон тухай мэдээллийг 2019.02.17-ны өдрийн 11:14 цагт хүлээн авсан.

3. Тонхил сумын "Хатавчийн ам" гэдэг газар сумын төвөөс зүүн зүгт 30 км-т /Ө-46°03'36", У-94°04'12"/ 2019.03.20-ны өдрийн 11:03 цагт 5.8, 11:14 цагт 4.5, 11:55 цагт 3.6, 12:08 цагт 4.1 магнитудын хүчтэй газар хөдлөлт тус тус болсон тухай мэдээллийг 2019.03.20-ны өдөр хүлээн авсан.


Онцгой байдлын газрын тусгай дугаарын 7048105 утсанд 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 11:32 цагт Шарга сум Ээвийн гарам гэдэг газар аймгийн төвөөс хойд зүгт 85 км-т онгоцны түлш ачсан "Hyundai HD" маркын 47-61 УБД улсын дугаартай автомашин мөсөнд суусан гэсэн дуудлагаар тус газраас 7 хүн, 2 техниктэй гарч ажиллан автомашиныг мөснөөс татан гаргасан байна.

Цасан болон шороон шуурганы тухай Онцгой байдлын газрын тусгай дугаарын 7048105 утсанд 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 17:00 цагт Цээл сумаас Цогт сумын чиглэлд цахилгаан бараа ачсан 45-46 УНА улсын дугаартай Nissan hino ачааны автомашин Цээл сумаас 02 дугаар сарын 12-ны өдрийн 18:00 цагт гараад сураггүй байна гэсэн дуудлагаар Эрэн хайх, аврах бүлэг гарч ажиллан 6 хүний амь нас, 2 техникийг авран хамгаалсан байна.

Холбооны газар


Суурин телефон цэгийн тоо 570, холбоо ашиглалтын орлого 169.9 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 118.9 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгийн 10 суудалтай интернетээр 900 хүнд үйлчилжээ.

Суурин утасны цэгийн тоо



■ 2019 оны VI сард ■ 2020 оны VI* сард

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төгрөгөөр



■ 2019 оны VI сард ■ 2020 оны VI* сард

Говь-Алтай аймгийн 2020 оны 8-10 дугаар сарын уур амьсгал

Уур амьсгалын дулааралтын улмаас 2000-2002, 2005, 2007, 2008, 2017 онд зуны гурван сард ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 2-5°C-аар дулаан байв. Олон хоног дараалан агаарын үнэмлэхүй их температур говийн нутгаар +40°C, хээрийн бүсэд +36°C, бусад нутгаар +32°C-аас давж халахыг их халуун гэж үздэг.

Долоо ба наймдугаар сард зуны улиралд орох борооны 70 гаруй хувь нь ордог бөгөөд төвийн нутгийн баруун, зүүн зүгийн нутгийн хойд болон зүүн өмнөд хэсгээр 78-107 мм, баруун ба говийн нутгаар 13-40 мм, бусад нутгаар 45-75 мм бороо ордог боловч 1980, 1981, 1988, 2000-2002, 2007, 2010, 2015, 2017 онд ихэнх нутгаар дунджаас харьцангуй бага бороо орж, гантай байв.

Уур амьсгалын дунджаар агаарын сарын дундаж температур есдүгээр сард Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр +15..+19°C, Алтай, Хангай, Хөвсгөлийн уулсаар +4..+8°C, бусад нутгаар +9..+14°C байдаг бол зургаа, наймдугаар сард Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр +21..+25°C, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар +10..+15°C, бусад нутгаар +16..+20°C байдаг.

Сүүлийн жилүүдэд их нутаг хамарсан зүс бороо орох тохиолдол багасч, ихэвчлэн түр зуурын ширүүн аадар бороо зурвас газраар орох нь ихсэж байна. Харин 1990, 1993, 1994, 1998, 2012,

2018 онд ихэнх нутгаар, 1997 онд нутгийн төв хэсгээр, 2003 онд нутгийн баруун хагаст уур амьсгалын дунджаас 1-3 дахин их бороо оржээ. 9 дүгээр сараас борооны хэмжээ багасаж, орох тохиолдол нь цөөрдөг ба төв ба зүүн зүгийн нутгийн хойд хэсгээр 32-44 мм, баруун ба говийн нутгаар 4-15 мм, бусад нутгаар 17-30 мм ордог ба зарим сэрүүн жилд сарын сүүлчээр уулархаг нутгаар нойтон цас ордог байна.


Намрын эхний цочир хүйтрэлт наймдугаар сард уулархаг нутаг болон газар тариалангийн бүс нутгаар голчлон ажиглагддаг. Есдүгээр сард цочир хүйтрэлт ажиглагдах тохиолдол нэмэгддэг онцлогтой.

Гурав. 8-10 ДУГААР САРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Наймдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун хэсгээр 0-12°C, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд хэсэг, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнодын ихэнх нутгаар 18-26°C, бусад нутгаар 12-18°C дулаан байдаг байна.

8 дугаар сарын агаарын температур Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв аймаг, Хэнтийн нийт нутгаар, Ховд, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Дорнодын хойд хэсгээр ОЖД-ийн орчим, бусад нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна (**1 дүгээр зураг**).


9



Зураг 1. 8 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(С⁰)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 70-100 мм, Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутаг, Завханы баруун, Өвөрхангайн өмнөд хэсгээр 10-40 мм, бусад нутгаар 40-70 мм ордог байна.


8 дугаар сарын нийлбэр хур тунадас Увсын ихэнх нутаг, Баян-Өлгий, Завханы хойд, Хөвсгөлийн баруун хэсгээр ОЖД-аас ахиу, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын нутгийн өмнөд хэсгээр, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн ихэнх нутгаар ОЖД-аас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**2 дугаар зураг**).



Зураг 2. 8 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

Есдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 4°C хүйтнээс 6°C дулаан, Өмнөговь, Дорноговийн нутаг, Говь-Алтайн, Баянхонгорын өмнөд хэсгээр $14-20^{\circ}\text{C}$, бусад нутгаар $6-14^{\circ}\text{C}$ дулаан байдаг байна.


➤дүгээр сарын агаарын температур нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**3 дугаар зураг**).



Зураг 3. 9 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв($^{\circ}\text{C}$)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Сэлэнгийн нутгаар 30-40 мм, Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутаг, Хөвсгөл, Булган, Төв, Хэнтий, Дорнодын хойд Завхан, Сүхбаатарын баруун өмнөд, Өвөрхангайн өмнөд хэсгээр 4-15 мм, бусад нутгаар 15-30 мм хур тунадас ордог байна.


9 дүгээр сарын нийлбэр хур тунадас Дорноговийн ихэнх нутаг, Өмнөговийн зүүн хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар ОЖД-ийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**4 дүгээр зураг**).



Зураг 4. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

Аравдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр $2-10^{\circ}\text{C}$ хүйтэн, Өмнөговь, Дорноговийн нутаг, Говь-Алтайн, Баянхонгорын өмнөд хэсгээр $4-8^{\circ}\text{C}$, бусад нутгаар 1°C хүйтнээс 3°C дулаан байдаг байна.


10 дугаар сарын агаарын температур нийт нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна (**5 дугаар зураг**).



Зураг 3. 9 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(С⁰)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар баруун болон говийн аймгуудын ихэнх нутгаар 3-6 мм, бусад нутгаар 7-15 мм хур тунадас ордог байна.

❖ дугаар сарын нийлбэр хур тунадас Булган, Сэлэнгэ, Төв аймаг, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дундговь, Дорноговийн ихэнх нутгаар ОЖД-аас бага, бусад нутгаар ОЖД-ийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**6 дугаар зураг**).



Зураг 4. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

2020 оны зуны улирлын онцлог: Урьдчилсан төлөвөөс харахад 8 дугаар сард нутгийн өмнөд хэсгээр, 10 дугаар сард ихэнх нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй. Хур тунадасны хувьд ихэнх нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй, ялангуяа 8 дугаар сард хур тунадас нь нутгийн баруун өмнөд болон нутгийн зүүн хэсгээр ОЖД-аас бага байх төлөвтэй.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаг агаарын гамшигт үзэгдлийн давтагдал, эрч хүч нэмэгдэж байгаа тул зуны хугацаанд зурвас газраар үе үе ширүүн аадар бороо, мөндөр орж, үер буух, салхины түр зуурын хүчтэй ширүүсэлт ажиглагдах магадлалтай байна. Мөн 9 дүгээр сард нойтон цас орж тариа, хүнсний ногоо цасанд дарагдах зэрэг байгаль цаг агаарын тааламжгүй нөхцөл ажиглагдаж болзошгүй. Аадар хур тунадас орсны дараа гол, мөрний усны түвшин огцом нэмэгдэж, үер, усны аюул тохиолдож болзошгүй байгааг урьдчилан анхааруулж байна.

Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшинээр	By educational level	2016.XII	2017.XII	2018.XII	2019.XII	6-сар In June	
						2019	2020
Бүгд	Total	786	796	919	964	515	1040
Үүнээс: эмэгтэй	of which:female	435	430	462	514	287	498
Дээд боловсролтой	Higher education	265	280	226	229	153	236
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	35	49	46	56	18	41
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	70	66	72	81	59	82
Бүрэн дунд	Upper secondary school	341	331	475	499	243	586
Суурь	Compulsory secondary school	42	41	59	59	23	63
Бага	Primary school	28	27	23	21	14	15
Боловсролгүй	Uneducated persons	5	2	18	19	5	17

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2020 оны 6 сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of June 2020**

Үүнээс: насны бүлгээр of which:by age group

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	15-24	25-34	35-44	45-59	55-59	60+						
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female						
I	727	353	194	99	251	124	149	75	94	43	31	8	8	4
II	835	412	185	95	300	149	191	98	109	52	38	12	12	6
III	850	397	158	71	296	137	214	112	130	58	38	12	14	7
IV	901	428	174	77	304	145	230	119	143	67	35	13	15	7
V	994	475	188	79	325	153	266	141	163	80	35	14	17	8
VI	1040	498	212	88	327	154	263	143	175	87	44	17	19	9

2020 ОНЫ 6 САРД АЖИЛГҮЙЧҮҮДЭЭС ТАЙЛАНТ САРД АЖИЛД ОРСОН ХҮН
NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 6 months of 2020

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллага Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I	99		93	5		1
II	11		8	3		
III	35		23	9		3
IV	98	2	32	62		2
V	29		6	12		11
VI	24	3	21			

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР
NUMBER OF UNEMPLOYED, by som

Ної	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2016.XII	2017.XII	2018.XII	2019.XII	6-р сар June		
						2019	2020	2020% 2019
Есөнбулаг	Yesunbulag	326	353	487	453	256	511	199.6
Алтай	Altai	10	27	17	30	6	21	350.0
Баян-Уул	Bayan-Uul	40	28	30	35	12	42	350.0
Бигэр	Biger	35	24	29	38	18	23	127.8
Бугат	Bugat	19	31	30	28	12	39	325.0
Дарив	Darib	17	12	54	40	42	34	81.0
Дэлгэр	Delger	44	75	24	41	13	32	246.2
Жаргалан	Jargalan	11	6	11	12	6	8	133.3
Тайшир	Taishir	15	16	3	15	4	21	525.0
Тонхил	Tonhil	20	11	30	30	12	62	516.7
Төгрөг	Tugrug	21	16	21	17	6	13	216.7
Халиун	Haliun	25	30	25	27	16	34	212.5
Хөхморьт	Huhmorit	34	16	12	34	8	22	275.0
Цогт	Tsogt	61	63	38	53	24	47	195.8
Цээл	Tseel	15	16	33	30	37	55	148.6
Чандмана	Chandmana	34	45	42	42	36	49	136.1
Шарга	Sharga	34	12	18	15	4	12	300.0
Эрдэнэ	Erdene	25	15	15	24	3	15	500.0
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	-	-					
ДҮН	TOTAL	786	796	919	964	515	1040	201.9

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
PUBLIC HEALTH OF POPULATION

№	Сумын нэр	Soum	Төрсөн эх Women who gave births		Эхийн эндэгдэл Maternal Deaths		Төрсөн хүүхэд Births		Нялхасын эндэгдэл Infant mortality		1-5 хүртэлх настай хүүхдийн эндэгдэл Under-five mortality		Нийт нас баралт Deaths		Эмнэлэгт нас баралт Deaths	
			2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
			1	Есөнбулаг	Yesunbulag	614	651			622	655	11	4	1		69
2	Алтай	Altai	5	11			5	11			1		4	8		2
3	Баян-Уул	Bayan-Uul	1	3			1	3		1	1		12	11	2	1
3	Бигэр	Biger	7	2			7	2					3	4		
4	Бугат	Bugat	3	5			3	5					8	5	1	1
5	Гуулин	Gulin											0	3		1
5	Дарив	Darib	3	7			3	7	1	1			1	6		3
6	Дэлгэр	Delger	4	3			4	3					2	7	1	1
7	Жаргалан	Jargalan		1				1					2	2		2
8	Тайшир	Taishir		1				1					7	1		
8	Тонхил	Tonhil	5	4			5	4					5	6		1
9	Төгрөг	Tugrug	5	9			5	9	2				7	3	5	1
10	Халиун	Haliun	2	2			2	2					4	5	1	2
10	Хөхморьт	Huhmorit	2	1			3	1	1				7	5	4	
11	Цогт	Tsogt	3	4			3	4					6	4	1	1
12	Цээл	Tseel	2				2						3	4		
12	Чандмана	Chandmani	5	4			5	4					5	3		3
13	Шарга	Sharga								1			4	3		
14	Эрдэнэ	Erdene	5	2			4	2		1		1	8	6	1	
15	Баянтоорой	Bayantoroi		1				1					3	1	1	
22	Дүн	Total	666	711	0	0	674	715	15	8	3	1	160	139	36	31

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд <i>Infectious Diseases</i>		Үүнээс: Of which:													
					БЗХӨ STID						Гепатит <i>Hepatite</i>		Сүрьеэ <i>Tuberculosis</i>		Улаан бурхан		Бусад <i>Other</i>	
			2019	2020	Трихоминаз <i>Trichomoniasis</i>	2019	2020	Тэмбүү <i>Syphilis</i>	2019	2020	Заг хүйтэн <i>Gonorrhea</i>	2019	2020	2019	2020	2019	2020	2019
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	105	79	4	2	19	29	19	11			6	10			57	27
2	Алтай	<i>Altai</i>	1	4				1	1					2			0	1
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	14	9			2	2		3			1				11	4
3	Бигэр	<i>Biger</i>	0	3				1.0						2			0	0
4	Бугат	<i>Bugat</i>	10	6				2									10	4
5	Гуулин	<i>Gulin</i>	1	0							1						0	0
5	Дарив	<i>Darib</i>	5	1	1		1	1					2				1	0
6	Дэлгэр	<i>Delger</i>	5	8			1	1	1	1							3	6
7	Жаргалан	<i>Jargalan</i>	4	5			2	1	1				1	1			0	3
8	Тайшир	<i>Taishir</i>	6	2	1		1		1					1			3	1
8	Тонхил	<i>Tonhil</i>	4	2			2	1					1				1	1
9	Төгрөг	<i>Tugrug</i>	2	5			1	3						1			1	1
10	Халиун	<i>Haliun</i>	9	3			3	3					2				4	0
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>	5	4			1	2	2	1			1				1	1
11	Цогт	<i>Tsogt</i>	14	4			2	3	1	1							11	0
12	Цээл	<i>Tseel</i>	2	2			2	1									0	1
12	Чандмана	<i>Chandmani</i>	3	3			2	1					1				0	2
13	Шарга	<i>Sharga</i>	6	6			1	2	2		1			1			2	3
14	Эрдэнэ	<i>Erdene</i>	7	2			1	1.0	1					1			5	0
15	Баянтоорой	<i>Bayantoroï</i>	14	1				1									14	0
16	Харьяаллын бус		5	10		2	5	7		1								
22	Дүн	Total	222	159	6	4	46	63	29	18	2	0	15	19	0	0	124	55

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан, даатгалын төрлөөр
 REVENUE OF SOCIAL INSURANCE FUND AND INSURERS, by types of funds and insurance

Үзүүлэлт	Indicators	Сая төгрөг / Mln tugrug	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид / Pensionaries, who got pension from the social insurance fund
Нийгмийн даатгалын сангийн орлого	Revenue of social insurance fund	9273.0	9189
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	5978.1	8305
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	676.5	793
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	1918.2	0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	IAOD insurance fund	550.1	23
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	150.2	68
Нийгмийн даатгалд даатгуулагчид / The number of insurers			
Заавал даатгуулагчид / Compulsory insurers			8753
Сайн дураар даатгуулагчид / Voluntary insurers			3284
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид / Health insurance insurers			12745

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО ЗАРЛАГА, халамжийн төрлөөр
 REVENUE AND EXPENDITURE OF SOCIAL WELFARE SERVICES, by types of welfare

Үзүүлэлт	Indicators	Орлого сая.төг / Revenue	Зарлага сая.төг / Expenditure	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авсан иргэд / Beneficiaries of social welfare pensions, allowances, benefits and concession
Бүгд	Total	4514.3	4420.3	25119
Нийгмийн халамжийн үйлчилгээ	Social welfare services	2851.1	2783.8	8532
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	Allowance to pregnant and lactating mothers	20.0	19.6	835
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	Benefits for honored elders	30.0	29.5	29
Алдарт эхийн одонгийн тусламж	Allowances for elders with "The medal of glorious mother"	656.1	648.3	4960
Хүнс, тэжээлийн хөнгөлөлт	Benefits of food	282.0	281.4	5022
Насны хишиг	Age grace	398.3	395.4	2477
цалинтай ээж		131.8	131.8	3094
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж		100.0	97.5	125
ОНОТХҮйлчилгээ	Other welfare services	45.0	33.0	45

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН салбараар, (оны үнээр, мян.төг)

GROSS INDUSTRIAL OUTPUT, sector at current price thous.tug

Салбараар	2019 VI	2019 I-VI	2020 VI*	2020 I-VI*	$\frac{2020\text{ I-VI}^*}{2019\text{ I-VI}}$
A	1	2	3	4	5
Нийт дүн	815894.9	5127527.7	487402.1	6606595.6	128.8
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	0	703560.3	0	823056.4	117.0
Нүүрс олборлолт	0	703560.3	0	823056.4	117.0
Боловсруулах аж үйлдвэр	111746.4	450003	77038.8	424584.1	94.4
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	45027.9	339141	46937.3	307451.4	90.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	1410.6	15963.7	4175	20825	130.5
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	0	45750	0	15800	34.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15265	121032	25053.5	151975.3	125.6
Ундаа үйлдвэрлэл	28352.3	156395.3	17708.8	118851.1	76.0
Нэхмэлийн үйлдвэрлэл	2530.5	16904	0	10393.6	61.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1925	16870	9925	31762	188.3
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	93	2602	506.5	2707.1	104.0
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	400	3236	1400	6300	194.7
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	10446	15216	15050	46545	305.9
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	45704	46664	550	2750	5.9
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	4840	4840	0	0	0.0
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	780	4530	2670	16675	0.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	704148.5	3973964.4	410363.3	5358955.1	134.9
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	569566.6	3252633.5	293530	4772967.2	146.7
Ус ариутгал, усан хангамж	134581.9	721330.9	116833.3	585987.9	81.2

* Урьдчилсан гүйцэтгэл

* Times more

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар, (оны үнээр, мян.төг)
GROSS INDUSTRIAL OUTPUT, sector by soum, at current price thous.tug

Салбараар	2019 VI	2019 I-VI	2020 VI*	2020 I-VI*	$\frac{2020 VI^*}{2019 VI}$
А	1	2	3	4	5
Нийт дүн	817880.3	5290805.9	485578.4	6967820.6	131.7
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	0.0	786834.3	0.0	900239.5	114.4
Нүүрс олборлолт	0.0	786834.3	0.0	900239.5	114.4
Боловсруулах аж үйлдвэр	129131.8	532896.8	92575.1	497257.0	93.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	44044.3	379755.5	50065.1	323585.0	85.2
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	1733.3	19496.6	5400.0	26910.0	138.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	0.0	67150	0.0	24000.0	35.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	19944.8	174534.1	33485.0	205927.8	118.0
Ундаа үйлдвэрлэл	22366.2	118574.8	11180.1	66747.2	56.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	3423.0	24360.6	0.0	15740.0	64.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2535.0	24373	12570.0	41950.0	172.1
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	124.0	3578	760.0	4046.0	113.1
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	891.5	9735.7	2500.0	11350.0	116.6
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	14430.0	21320	21430.0	68296.0	0.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	56574.0	58074	750.0	3750.0	0.0
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	6090.0	6090	0.0	0.0	0.0
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1020.0	5610	4500.0	28540.0	508.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	688748.5	3971074.8	393003.3	5570324.1	140.3
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	621709.2	3503054.1	293530.0	5030098.0	143.6
Ус ариутгал, усан хангамж	67039.3	468020.7	99473.3	540226.1	115.4

* Урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, сумаар, 6 сар READING OG YOUNG ANIMALS, by type, soums, 6 month

Сум	Төллөсөн хээлтэгч						Гарсан төл					
	Бүгд	Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Бүгд	1241910	32355	25025	7144	397481	779905	1243244	32355	25025	7145	398125	780594
Есөнбулаг	93101	2327	1898	172	31826	56878	93101	2327	1898	172	31826	56878
Алтай	33742	393	333	351	5495	27170	33742	393	333	351	5495	27170
Баян-Уул	78242	1622	1202	283	28807	46328	78673	1622	1202	283	29007	46559
